

## ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

### БАНКНЫ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх/цаашид МУТС гэх/-тэй тэмцэх тухай хууль, Засгийн газрын тогтоол, бусад хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас гаргасан заавар, дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг хэрхэн тодорхойлж, үнэлэн, удирдаж байгаад газар дээр нь хяналт, шалгалт хийж үнэлгээ өгөх, дүгнэлт гаргахад энэ журмыг мөрдөнө.

1.2 МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийх хяналт шалгалтыг энэхүү журмын 3 дах хэсэгт тодорхойлсон бүх үнэлэх үзүүлэлтийг хамруулан иж бүрэн хэлбэрээр эсхүл МУТС-тэй тэмцэх чиглэлээр банкинд зайнаас тавих хяналтын дүгнэлт болон эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тодорхой нэг эсхүл хэд хэдэн үзүүлэлтийг сонгон хэсэгчилсэн хэлбэрээр хэрэгжүүлж болно.

1.3 МУТС-тэй тэмцэх чиглэлээр банкинд хийгдэх газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

#### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ БЭЛТГЭЛ

2.1 Хянан шалгагч нь газар дээрх хяналт шалгалтыг хийхийн өмнө шалгалтын хамрах хүрээ, үнэлэх үзүүлэлтийг харгалзан дараах баримт, мэдээлэлтэй танилцсан байх шаардлагатай. Үүнд:

2.1.1 тухайн банкнаас шалгалтын хамрах хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба/цаашид СМА гэх/-нд ирүүлсэн бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо, сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо, тэдгээрт гарсан өөрчлөлтийн тухай статистик мэдээлэл;

2.1.2 банк 2.1.1-д дурдсан тайлангуудыг хуульд заасан хугацаандаа бүрэн гүйцэт бөглөн ирүүлж байгаа эсэх болон дүн шинжилгээ хийхэд шаардлагатай лавлагаа, нэмэлт мэдээлэл авах хүсэлтэд хэрхэн хамтран ажиллаж байгаа талаар СМА-наас дүгнэлт гаргуулан авах;

2.1.3 СМА-нд бүртгүүлсэн МУТС-тэй тэмцэх чиглэлээр тухайн банкны баримтлах дотоод бодлого, журам тэдгээрт орсон өөрчлөлт;

2.1.4 өмнө хийгдсэн газар дээрх шалгалтын акт, материал;

2.1.5 зайнаас тавьсан хяналтын дүгнэлт болон тухайн банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлэгээ;

2.1.6 өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайлан;

2.1.7 банкны хувь нийлүүлэгч, удирдлага, өөрийн хөрөнгийн хэмжээ болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

2.1.8 бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрт орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл;

2.1.9 төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс ирүүлсэн мэдээлэл, өргөдөл болон олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр цацагдсан тухайн банктай холбоотой мэдээлэл.

2.2 Банкинд газар дээрх хяналт шалгалт хийхийн өмнө шалгалтын удирдамж, урьдчилан бэлтгэх баримт материалын жагсаалтыг банкны удирдлагад танилцуулж, гардуулж өгнө.

## ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

3.1 Хянан шалгагч нь банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийхдээ дараах үзүүлэлтийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилт болон учирч болох эрсдэлд энэ журамд зааснаар үнэлгээ, дүгнэлт өгнө:

3.1.1 МУТС-тэй тэмцэх банкны бүтэц зохион байгуулалт, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын оролцоо;

3.1.2 МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын хөтөлбөр;

3.1.3 харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэр, үйл ажиллагааны цар хүрээ, газар зүйн онцлогоос үүдэн гарах МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал түүний үр дүнтэй байдал;

3.1.4 МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн банкны дотоод хяналт, шалгалтын тогтолцоо, арга хэлбэр;

3.1.5 харилцагчийг таньж мэдэх, харилцагч, данс болон гүйлгээний талаарх баримт, материалын хадгалалт; Энэ үзүүлэлтэд банкны дараах үйл ажиллагааг хамруулан шалгана. Үүнд:

3.1.5.1 Харилцагчийг хялбаршуулан таньж мэдэх үйл ажиллагаа;

3.1.5.2 Харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагаа;

3.1.5.3 Улс төрд нөлөө бүхий этгээдийг таньж мэдэх;

3.1.5.4 Эцсийн өмчлөгийг тогтоох, таньж мэдэх үйл ажиллагаа;

3.1.5.5 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд гуравдагч этгээдийг ашиглах;

3.1.5.6 Дансгүй, тохиолдлын чанартай гүйлгээ хийж байгаа харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, цахим гүйлгээнд тавих хяналт;

3.1.5.7 Корреспондент банкны харилцаа тогтооход тавигдах шаардлагуудын хэрэгжилт;

3.1.5.8 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан баримт, материал шинэчлэлт, болон хаагдсан данс, хийгдсэн гүйлгээний талаарх баримт, материалын хадгалалт.

3.1.6 МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр түүний хэрэгжилт;

3.1.7 данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих болон, мэдээлэх үүрэгтэй холбоотой банкны үйл ажиллагаа; Энэ үзүүлэлтэд банкны дараах үйл ажиллагааг хамруулан шалгана. Үүнд:

3.1.7.1 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх банкны үйл ажиллагаа;

3.1.7.2 Данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих үйл ажиллагаа;

3.1.7.3 Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа болон Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн хоригийн тогтоол, ФАТФ-ын хар, саарал жагсаалтыг ашиглаж байгаа байдал;

3.1.7.4 Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа болон Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоол болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан террорист этгээдийн нэрсийн жагсаалтыг ашиглаж байгаа байдал;

3.1.7.5 Данс, гүйлгээг нэн даруй царцаах арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх;

3.1.7.6 Гадаад төлбөр тооцооны гүйлгээ болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх үйл ажиллагаа.

3.2 Хянан шалгагч нь 3.1-д дурдсан чиглэлээр хяналт шалгалт хийхдээ энэ журмын хавсралт 1-д үзүүлсэн аргачлалыг ашиглахын зэрэгцээ өмнөх газар дээрх шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, банкнаас өгсөн статистик мэдээлэл, асуулгын хариулт нь бодит байдалд нийцэж буй эсэхийг хянана.

## ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

4.1 МУТС-тэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтыг хийхдээ ажлын хэсгийн гишүүд нь өөрсдийн хариуцаж хяналт, шалгалт хийсэн чиглэл тус бүрээр илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хариуцлагыг тооцохын зэрэгцээ тухайн чиглэлээр банк МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг хэрхэн удирдаж байгаад 1-ээс 5-ын хооронд тоон үнэлгээ өгч дараах байдлаар

дүгнэнэ. Үүнд:

- i. 1 буюу сайн;
- ii. 2 буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд;
- iii. 3 буюу дутагдалтай;
- iv. 4 буюу ихээхэн дутагдалтай;
- v. 5 буюу хангалтгүй;

4.1.1 Хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь хянан шалгагч нарын хэсэг тус бүрт өгсөн үнэлгээнд үндэслэн банкны МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг дээрхийн адил 1-ээс 5-ын хооронд тоон үнэлгээгээр нэгтгэн дүгнэнэ.

4.2 Эрсдэлд суурилсан хэсэгчилсэн хяналт шалгалт хийгдсэн тохиолдолд нэгдсэн дүгнэлт хийгдэхгүй зөвхөн шалгалт хийсэн чиглэлийн дагуу харгалзах үнэлгээг өгнө.

4.3 Банкны МУТС эрсдэлийн удирдлагын дүгнэлттэй холбогдуулан дараах арга хэмжээг авна:

4.3.1 “дутагдалтай” гэж дүгнэсэн тохиолдолд банкинд хугацаат үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавиж ажиллана;

4.3.2 “ихээхэн дутагдалтай” гэж дүгнэсэн тохиолдолд тухайн банкинд хугацаат үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавиж ажиллахын зэрэгцээ банкны удирдлагатай хийх уулзалт болон хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

4.3.3 “хангалтгүй” гэж дүгнэсэн тохиолдолд тухайн банкинд авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээний саналыг Монголбанкны Ерөнхийлөгч болон Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлд танилцуулна.

#### ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ҮҮРЭГ

5.1 Газар дээрх хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч, гишүүд нь Монголбанкны улсын байцаагчийн дүрэмд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, улсын байцаагчийн үйл ажиллагаандаа мөрдөх зарчмыг баримтлан ажиллана.

5.2 Газар дээрх шалгалттай холбоотой гомдол, санал, тайлбарыг хүлээн авах, шийдвэрлэхэд Монголбанкны улсын байцаагчийн дүрмийг баримтлана.

5.3 Хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

5.3.1 шалгалтын чиглэл, удирдамжийн талаар банкны удирдлага болон холбогдох ажилтнуудад танилцуулж, мэдээлэл хийнэ;

5.3.2 хянан шалгагч нарын ажил үүргийн хуваарийг хийж, шалгалтын явцад хянан шалгагч нарын ажилтай танилцаж, заавар зөвлөгөө өгч, шалгалтыг хугацаанд нь дуусгах талаар санаачлага гарган ажиллана;

5.3.3 нэмэлт хугацаа шаардлагатай бол энэ талаар удирдлагад хүсэлт гаргана;

5.3.4 хяналт шалгалт хийж дууссанаас хойш ажлын долоон өдөрт багтааж шалгалтын акт материал болон шалгалтын мөрөөр авах арга хэмжээний саналыг Монголбанкны Хяналт шалгалтын зөвлөлд танилцуулахад бэлэн болгоно;

5.3.5 ажлын хэсгийн ахлагч шалгалтын акт материалыг Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, түүний мөрөөр гарсан шийдвэрийг банкинд хүргүүлэх арга хэмжээг авсны дараагаар банкны эрсдэлийн үнэлгээг шинэчлэн шалгалтын акт материалыг банкны хувийн хэрэгт хавсаргана.

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1 Энэхүү журмыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

“Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын хавсралт 1

## ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГАЧЛАЛ

ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:

*МУТС-тэй тэмцэх банкны бүтэц зохион байгуулалт, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын оролцоо/журмын 3.1.1-д хамаарна/;*

**Зорилт:**

МУТС-тэй тэмцэх олон улсын стандарт болон дотоодын хууль тогтоомж нь банк, санхүүгийн байгууллагад чиглэгдсэн бөгөөд банкны хувь нийлүүлэгчдийн хувьд хууль тогтоомжийг үл хайхарсан тохиолдолд бизнесийн хэвийн үйл ажиллагааг нь алдагдах, бүр мөсөн зогсох хүртэл эрсдэлтэй тул өмчийн эзэд тэдний төлөөлөл болсон ТУЗ нь МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Тиймээс МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаа нь эцсийн дүндээ банкны ТУЗ-ын үүрэг хариуцлага бөгөөд ТУЗ нь МУТС-тэй тэмцэх бүтэц зохион байгуулалт, хяналтын тогтолцоог бий болгон, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах үүрэг хүлээнэ.

Банкны гүйцэтгэх удирдлага ТУЗ-аас баталсан МУТС-тэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн талаар ТУЗ-д дэлгэрэнгүй тайлагнахын зэрэгцээ банкны МУТС эрсдэлийн үнэлгээг хийж авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх үүрэгтэй. МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйл “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт” гэсэн хэсэгт зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээг дурдсан. Үүний зэрэгцээ хянан шалгагч нь банкны дотоод бодлого журам нь үйл ажиллагааныхаа цар хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогод тохирч байгаа эсэх хийгээд банк МУТС эрсдэлийг хянаж, удирдаж чадаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийхийг зорино.

### **Шалгуур үзүүлэлт:**

1. ТУЗ нь МУТС-тэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, МУТС эрсдэлийг удирдахад чиглэсэн банкны дотоод бодлого, журам, аргачлалыг баталсан эсэх;

2. Дээрх бодлого, журам, аргачлал нь банкны харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, газар зүйн онцлог, бизнесийн цар хүрээ, МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээнд нийцтэй эсэх;

3. Бодлого, журам нь үр дүнтэй хэрэгжих боломжийг хангахаар хоорондоо уялдаа холбоотой, хэн юу хийх нь тодорхой байж чадаж байгаа эсэх;

4. Бодлого журмын хэрэгжилт болон МУТС эрсдэлийн талаар ТУЗ болон хувь нийлүүлэгчдийг хэрхэн мэдээллээр хангаж байгаа байдал, тайлан, мэдээллийн давтамж, агуулга нь оновчтой, дэлгэрэнгүй байж чадаж байгаа эсэх;

5. ТУЗ-д танилцуулж байгаа тайланд банкны МУТС эрсдэлийн үнэлгээ, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай санал, дүгнэлт оруулдаг эсэх; Банкны гүйцэтгэх удирдлага, хэрэгжилт хариуцсан нэгжид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр аливаа хүндрэл бэрхшээл гардаг эсэх, гарсан хүндрэл бэрхшээлийг банкны ТУЗ-д мэдээлдэг эсэх;

6. Банкны ТУЗ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хөтөлбөрийн үр дүнтэй ажиллаж байгааг эсэхийг хэрхэн үнэлдэг, хэрэгжилтэд гарч буй алдаа дутагдлыг цаг тухайд илрүүлэх, засч залруулах механизмтай эсэх;

7. Банк нь гүйцэтгэх удирдлагаас хараат бус дотоод хяналтын тогтолцоотой эсэх; Дотоод хяналтын нэгж нь банкны МУТС эрсдэлийг хэрхэн удирдаж байгаад тавих хяналт нь оновчтой, үр дүнтэй эсэх;

8. Банкны гүйцэтгэх удирдлага ТУЗ, Дотоод хяналтын нэгжийн зөвлөмж, шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлж, арга хэмжээ авдаг эсэх, авсан арга хэмжээ үр дүнг шалгах;

9. Банкны ТУЗ МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журмыг эргэн харж, шинэчилдэг эсэх; ямар хугацааны давтамжтай шалгаж, шинэчилдэг.

10. Банкны МУТС-тэй тэмцэх бүтэц зохион байгуулалтыг хийж хариуцах нэгж, ажилтныг томилсон эсэх;

11. Банкны ТУЗ эсхүл гүйцэтгэх удирдлагаас хэрэгжилт хариуцсан нэгжийн үйл ажиллагааны чиглэл, ажилтнуудын ажлын байрны үүрэг хариуцлагыг тодорхойлж гаргадаг эсэх;

12. Банкны гүйцэтгэх удирдлагыг хэрэгжилт хариуцсан нэгж хэрхэн мэдээллээр хангадаг, мэдээллийн давтамж, агуулга оновчтой эсэх;

13. Банкны МУТС-тэй тэмцэх нэгж/ажилтан үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоогоор хангагдсан эсэх; Данс, гүйлгээ, харилцагчийн мэдээлэлд нэвтрэх эрх олгогдсон эсэх, тусгайлан хяналт тавих, хэвийн бус гүйлгээг илрүүлэх, жагсаалтад орсон этгээд мөн эсэхийг тогтоох, бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг бэлтгэхэд ашиглах програм хангамжтай эсэх; Бусад газар нэгжтэй хэрхэн хамтран ажилладаг, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг цаг хугацаанд нь гаргуулан авах, салбар тооцооны төвд хууль, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах боломж бүрдсэн эсэх, хүний нөөц, ажилтнуудын мэргэшсэн байдал, төсөв, техник хэрэгслэлээр бүрэн хангагдсан эсэх;

14. Банк шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, эсхүл тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийг өөрчлөх, шинэ технологи нэвтрүүлэхийн өмнө тэдгээрийн МУТС зорилгоор ашиглагдах эрсдэлийг үнэлж санал, дүгнэлт боловсруулан ТУЗ, түүний дэргэдэх хороодоор хэлэлцүүлдэг эсэх;

### **Шалгах арга хэлбэр:**

1. Банкны ТУЗ, түүний дэргэдэх хороодын хэлэлцсэн асуудал, хурлын тэмдэглэл, гарсан тогтоол шийдвэртэй танилцаж;

2. Гүйцэтгэх удирлагын гаргасан шийдвэрүүдтэй танилцах;

3. Хэрэгжилт хариуцсан нэгжийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад танилцуулсан материалтай танилцах;

4. Дотоод хяналт шалгалтын нэгжийн бүтэц, зохион байгуулалт, МУТС-тэй тэмцэх чиглэлээр хяналт, шалгалт хийх аргачлал, хамрах хүрээ, давтамж, шалгалтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй танилцах;

5. Хэрэгжилт хариуцсан нэгж, ажилтны ажлын байрны тодорхойлолт, ажиллах нөхцөл, банкны ТУЗ түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлага болон банкны бусад газар, хэлтэс, нэгжтэй хэрхэн хамтран ажиллаж байгаатай танилцах, дотоод үйл ажиллагааны журмын холбогдох заалтуудтай танилцах,

6. Банкны гүйцэтгэх удирдлага, хэрэгжилт хариуцсан нэгжийн удирдлага, хэрэгжилт хариуцсан ажилтантай ярилцлага хийх;

7. Өмнөх шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд банкны бүтэц зохион байгуулалттай холбоотой өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянах.

#### ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:

*МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам болон хяналтын хөтөлбөр /журмын3.1.2-т хамаарна/*

#### **Зорилт:**

Банк МУТС-тэй тэмцэх тухай хууль, Засгийн газрын тогтоол, тэдгээртэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журам, зааврыг өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг удирдахад чиглэсэн дотоод бодлого, журамтай байх шаардлагатай. Дотоод бодлого, журам нь хэрэгжих боломжтой байхын зэрэгцээ хэн, юуг, хэрхэн хийхийг тодорхой зохицуулсан байвал зохимжтой. Хянан шалгагч нь банкны дотоод бодлого, журам хуульд хэрхэн нийцэж байгааг шалгахаас гадна банкны МУТС эрсдэлийг бууруулах үр дүнтэй тогтолцоо, арга замыг бий болгож чадаж байгаа эсэхийг анхаарна. Банкны дотоод бодлого журам нь банк оролцогч нь болох банкны нэгдлийн хэмжээнд хэрэгжиж байгаа эсэхийг анхаарна.

#### **Шалгуур үзүүлэлт:**

1. МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журамтай эсэх;

2. Харилцагчийн хувийн мэдээлэл, өмчийн хэлбэр, эрхэлж буй ажил, бизнесийн төрөл, банкнаас авч буй бүтээгдэхүүн үйлчилгээ, байнга оршин суудаг эсхүл бүртгэлтэй



болон үйл ажиллагаагаа явуулдаг газар, хийж буй гүйлгээний утга, төрөл, хэв байдал, болон мөнгөн дүн зэргээс хамааруулан харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлэх аргачлал бодлого, журамд нь байгаа эсэх;

3. Эрсдэлийн үнэлгээг хийхдээ МУТС чиглэлээр хийгдсэн Үндэсний эрсдэлийн үнэлгээг харгалзан үзэх талаар бодлого, журамд зохицуулалт байгаа эсэх;

4. Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа бодлого журамд туссан эсэх;

5. Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хугацаа алдалгүй, шуурхай хэрэгжүүлэх зохицуулалт байгаа эсэх;

6. Банк өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээ тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, салбар, тооцооны төвийн байршил тэдгээрийн харилцагчдын онцлог зэргээс хамаарсан эрсдэлийн үнэлгээ хийж МУТС эрсдэлийг удирдах зохицуулалттай эсэх;

7. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, техник технологи нэвтрүүлэх, эсхүл тэдгээрт өөрчлөлт ороход хэрэгжилт хариуцсан нэгжээс тэдгээрийн МУТС зорилгоор ашиглагдах эрсдэлийг нь тооцож, эрсдэлийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт авах дотоод зохицуулалт байгаа эсэх;

8. Харилцагчийг таньж мэдэх талаар банкны баримтлах бодлого, журам тодорхой эсэх;

9. Өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчлан таних үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой заалтууд байгаа эсэх;

10. Эцсийн өмчлөгчийг тогтоох зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой эсэх;

11. Хялбаршуулсан хэлбэрээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд хэзээ, хэнийг хамруулан хэрхэн хийх талаар тодорхой заалтууд байгаа эсэх;

12. Дансгүй эсхүл тогтвортой санхүүгийн харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартай гүйлгээ хийх, үйлчлүүлэх тохиолдолд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэзээ, хэрхэн хийх талаар зохицуулалт байгаа эсэх;

13. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх, эсхүл гуравдагч этгээдийн хийсэн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой хууль тогтоомжид нийцтэй заалтууд байгаа эсэх;

14. Корреспондент банкны харилцаа тогтооход баримтлах бодлого, журам байгаа эсэх түүнд орсон заалтууд хууль тогтоомжид нийцтэй, тодорхой эсэх;

15. Гадаад төлбөр тооцоо, банк хоорондын гүйлгээнд харилцагчийг таньж мэдэх шаардлагууд тодорхой эсэх;

16. Мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам, заавартай эсэх;

17. Бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх үүргийн хэрэгжилтийг хэрхэн хангуулах талаар зохицуулалт байгаа эсэх;

18. Сэжигтэй гүйлгээг таних, илрүүлэх, данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан эсэх;

19. ХТМ үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан, баримт мэдээлэл болон данс, гүйлгээтэй холбоотой баримт мэдээллийг хадгалах, мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах талаар зохицуулалт байгаа эсэх;

20. МУТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий хэрэгжилтэд хяналт тавих нэгж/ажилтны эрх үүрэг, банкны удирдлага болон бусад газар нэгжтэй хэрхэн хамтран ажиллах нь тодорхой эсэх;

21. Эдгээр зохицуулалт нь банкны салбар, тооцооны төв зэрэг бүх нэгжид хэрэгжих боломжтой эсэх;

22. Дотоод бодлого журмын хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо, үр дүнтэй байдлыг нь үнэлэх, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн эсэхийг тогтоох арга хэлбэр тодорхой эсэх;

23. Банкны дотоод бодлого журам нь банк оролцогч нь болох банкны нэгдлийн хэмжээнд хэрэгжихээр зохицуулсан эсэх.

### **Шалгах арга хэлбэр:**

1. МУТС-тэй тэмцэх чиглэлийн бүх бодлого журмын жагсаалтыг гаргуулан авч жагсаалтын дагуу бодлогын журмын батлагдсан, эх хувьтай танилцах;

2. Хууль тогтоомжид заасан шаардлагуудыг орхигдуулсан, хамрах хүрээ, үүрэг хариуцлагыг сулруулсан заалтууд орсон эсэхийг хянах;

3. Банкны гүйцэтгэх удирдлага, хэрэгжилт хариуцсан нэгжийн удирдлага, хэрэгжилт хариуцсан ажилтан болон банкны холбогдох ажилтантай ярилцлага хийх;

4. Урьдчилан бэлдсэн асуулгыг ашиглан хариулт авч хянах;

5. Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны дэс дараалал, хоорондын уялдаа холбоо, нэгжүүдийн МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийх ажлын чиг үүргийг харуулсан схемийг гаргаж, зохицуулалтын гадна үлдсэн, орхигдсон харилцаа, байгаа эсэхийг хянах;

6. Зохицуулалтын сул талыг олж харах, сайжруулах, илүү тодорхой болгох шаардлагатай зохицуулалтыг тодорхойлох;

7. Банкны дотоод бодлого, журам нь өөрийн МУТС эрсдэлийг хянах, эрсдэлийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах бололцоог бүрдүүлж чадаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

8. Өмнөх шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд банкны дотоод бодлого, журамтай холбоотой өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянах.

#### ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:

*Харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэр, үйл ажиллагааны цар хүрээ, газар зүйн онцлогоос үүдэн гарах МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал түүний үр дүнтэй байдал/журмын 3.1.3-т хамаарна/;*

#### **Зорилт:**

Банк МУТС-ээс урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэхэд шаардлагатай нөөц бололцоог үр дүнтэй ашиглах, өндөр эрсдэлтэй гэж үзсэн чиглэлд илүү анхаарал хандуулах боломжийг бүрдүүлэх үүднээс эрсдэлийн үнэлгээг хийж байх шаардлагатай юм. ФАТФ-ын 40 Зөвлөмжид банк, санхүүгийн байгууллага өөрийн харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, газар зүйн байршлаас хамааруулан МУТС эрсдэлийн үнэлгээг хийхийг зөвлөсөн байдаг. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ бүр өөр өөрийн онцлогтой бөгөөд зарим нь МУТС зорилгоор ашиглагдах магадлал өндөртэй байдаг. Жишээлбэл гадаад төлбөр тооцооны үйлчилгээ, гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээ, банкинд биечлэн ирэлгүй зайнаас данс нээлгэн үнэт цаасны арилжаанд оролцох, интернет банкны үйлчилгээ гэх мэт МУТС зорилгоор ашиглахад харьцангуй дөхөм бүтээгдэхүүн үйлчилгээ байдаг. Ерөнхийлөн авч үзвэл төлбөр тооцооны бүтээгдэхүүн үйлчилгээ хамгийн өндөр эрсдэлтэй бол зээлийн бүтээгдэхүүн нь бохир мөнгийг банкны системд оруулах бус харин банкнаас мөнгө зээллэж байгаа нөгөө талаас харьцангуй сайн судалж таньж байж олгодог тул эрсдэл багатай байдаг. Гэхдээ энэ нь зээл авах замаар мөнгө угаах боломжгүй гэсэн үг огт биш.

Түүнчлэн банкны зарим харилцагч нь гэмт хэрэг ихээхэн гардаг, МУТС-тэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй улс орны харьяат байх, эсхүл бэлэн мөнгө ихээр ашигладаг бизнес эрхэлдэг байх, улс төрд нөлөө бүхий этгээд, шашны зарим нэг хэт туйлширсан урсгалыг дэмжих, дэлгэрүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, хэн нэгний өмнөөс санхүүгийн харилцаанд орж байгаа хувийн хуульч эсхүл нягтлан бодох болон санхүүгийн мэргэжилтэн байх магадлалтай. Иймээс банк харилцагчдын МУТС эрсдэлийн төвшинг үнэлж түүнд тохирсон хэлбэрээр харилцагчийг таньж мэдэх /цаашид ХТМ гэх/ үйл ажиллагааг явуулах, тусгайлан хяналт тавих гэх мэт шаардлагатай арга

хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Эрсдэлийн үнэлгээг оновчтой хийх нь МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой.

Энэ хэсэгт хянан шалгагч нь банк өөрийн харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон газар зүйн онцлогоос хамаарах МУТС эрсдэлийг оновчтой тодорхойлж, удирдаж чадаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорино.

### **Шалгуур үзүүлэлт:**

1. Банк МУТС эрсдэлийг үнэлэх аргачлалыг баталсан эсэх;
2. МУТС эрсдэлийг үнэлэх аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих арга хэлбэрийг тодорхой зохицуулсан эсэх;
3. Эрсдэлийг үнэлэх аргачлал нь хэрэгжих боломжтой эсэх, МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээтэй уялдаа холбоо байгаа эсэх;
4. Эрсдэлийг үнэлэх аргачлал нь банкны харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс үүдэх эрсдэл болон салбар нэгжийн байршил, газар зүйн байршил болон валютын төрлөөс үүдэн гарах эрсдэлийг оновчтой гаргаж ирж чадаж байгаа эсэх;
5. Эрсдэлийн үнэлгээг хийх давтамж нь оновчтой эсэх;
6. Банк шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэхдээ түүний МУТС зорилгоор ашиглах эрсдэлийг үнэлдэг эсэх;
7. Хийгдсэн эрсдэлийн үнэлгээний дүнг үйл ажиллагаандаа хэрхэн ашигладаг, ТУЗ-д танилцуулдаг эсэх;
8. Банк өөрийн харилцагчдын эрсдэлийн төвшинг үнэлж, түүний дагуу ангилан өндөр эрсдэлтэй харилцагчдын хувьд эрсдэлийг удирдахад чиглэсэн нэмэлт арга хэмжээ авдаг эсэх;
9. Эрсдэлийн үнэлгээний аргачлалын хэрэгжилтэд банкны дотоод хяналтын нэгж хэрхэн хяналт тавьдаг.

### **Шалгах арга хэлбэр:**

1. ТУЗ-ийн баталсан эрсдэлийг үнэлэх аргачлал, бодлого, журамтай танилцах;
2. Шалгалтын хамрах хугацаа болон түүнээс өмнө хийгдсэн эрсдэлийн үнэлгээтэй танилцах;

3. Эрсдэлийн үнэлгээний дараагийн үе шат буюу эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан авч хэрэгжүүлсэн ажлын тайлантай танилцах, хэрэгжилт хариуцсан ажилтан болон холбогдох газар, нэгжийн удирдлагатай ярилцлага хийх;

4. Өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч байгаа эсэх, тэдгээрийн хувьд ХТМ үйл ажиллагааг нарийвчилсан хэлбэрээр явуулсан эсэхийг холбогдох бичиг баримтыг гаргуулан авч үзэх;

5. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан тусгайлан хяналт тавьсан болон тавьж байгаа данс, гүйлгээтэй холбоотой дүгнэлт, цуглуулсан нэмэлт материалтай танилцах;

6. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан сэжигтэй гэж үзсэн гүйлгээ байгаа эсэхийг тодруулж, сэжигтэй гүйлгээний тайлангийн бүртгэлтэй танилцах;

7. ТУЗ-д эрсдэлийн үнэлгээний талаар танилцуулсан байдал, түүний дагуу ТУЗ-өөс гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгавартай танилцах;

8. Эрсдэлийн үнэлгээний аргачлал, түүний хэрэгжилтэд банкны дотоод хяналтын нэгжээс хийсэн шалгалтын дүгнэлт, өгөгдсөн үүрэг даалгавар болон түүний хэрэгжилттэй танилцах;

9. Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах;

10. Тусгайлан хяналт тавих, ХТМ банкны үйл ажиллагаа болон мэдээлэх үүргийн хэрэгжилтийг шалгаж байгаа бусад хянан шалгагч нартай мэдээлэл солилцон хамтран ажиллах.

**ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:**

***МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн банкны дотоод хяналт шалгалтын тогтолцоо /журмын 3.1.4-т хамаарна/;***

**Зорилт:**

Энэ хэсэгт хянан шалгагч банкны МУТС-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хууль тогтоомж, банкны дотоод бодлого, журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьж банкны өмчийн эзэд болон тэдний төлөөлөл болсон ТУЗ-ийг мэдээлэлээр хангах тогтолцоо тухайн банкинд бүрдсэн эсэх, уг тогтолцооны үр дүнтэй, оновчтой байдалд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорино.

Банкны дотоод хяналт шалгалтын нэгж нь гүйцэтгэх удирдлага болон түүний баг ТУЗ-ийн баталсан МУТС-тэй тэмцэх бодлого, журмын дагуу ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, алдаа дутагдлыг засж залруулах арга хэмжээ авах, болон бодлого, журамд өөрчлөлт оруулах, сайжруулах шаардлага байгаа эсэхийг тодруулах үүрэгтэй.

**Шалгуур үзүүлэлт:**

1. Гүйцэтгэх удирдлагаас хараат бус дотоод хяналт, шалгалтын нэгж байгуулсан эсэх, уг нэгж нь хүний нөөц, ажиллах боломж нөхцөлөөр хангагдсан эсэх;

2. Дотоод хяналтын нэгжийн ажилтнуудын МУТС-тэй тэмцэх олон улсын стандарт, дотоодын хууль эрх зүйн орчин, МУТС эрсдэлийн талаарх ойлголт ямар түвшинд байгаа, энэ чиглэлээр сургалтад хамрагдсан байдал;

3. МУТС-тэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалт хийх журам, гарын авлага, сургалтын хөтөлбөртэй эсэх;

4. МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийх дотоод хяналт шалгалтын аргачлал, хамрах хүрээ, давтамж оновчтой эсэх;

5. Шалгалтыг дүнг ТУЗ, түүний дэргэдэх хороодоор хэлэлцүүлдэг эсэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалыг засж залруулах, сайжруулах талаар авч буй арга хэмжээ нь үр дүнтэй эсэх.

### **Шалгах арга хэлбэр:**

1. Дотоод хяналтын нэгжийг байгуулсан тухай ТУЗ-ийн тогтоол, шийдвэртэй танилцаж, бүтэц, бүрэлдэхүүн, эрх үүрэгтэй нь танилцах;

2. ТУЗ-ийн баталсан дотоод хяналт шалгалтын журамтай танилцах, Дотоод хяналт шалгалтын нэгжийн удирдлага ажилтнуудын МУТС эрсдэлийн талаарх ерөнхий ойлголт, хяналт шалгалтыг хэрхэн хийдэг, өөрийн банкны тухайд хаана өндөр эрсдэлтэй гэж үздэг талаар ярилцлага хийх;

3. Хяналт шалгалтын хуваарь, хамрах хүрээг хэрхэн тодорхойлдог, хэрвээ эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоотой бол эрсдэлийг хэрхэн үнэлдэг аргачлалтай танилцах;

4. ХТМ, өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчлан таних, дансгүй харилцагч банк хоорондын гүйлгээ, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ авахад ХТМ үйл ажиллагаа, тусгайлан хяналт тавих болон мэдээлэх үүргийн хэрэгжилтийг шалгах аргачлал, шалгалтын үр дүнтэй танилцаж оновчтой, үр дүнтэй байдалд нь дүгнэлт хийх;

5. Хэрэгжилт хариуцсан ажилтны ажил үүргийг ямар үзүүлэлтээр хэрхэн дүгнэдэг, сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг хэрхэн шалгадаг болохыг тогтоох;

6. Орон нутаг болон банкны бусад салбар нэгжид шалгалт хийхдээ банкны МУТС-тэй тэмцэх бодлого, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийдэг эсэхийг нягтлах, шалгалтын материалуудыг түүвэрлэн үзэх;

7. Сүүлийн 2 ба түүнээс дээш удаа хийсэн хяналт шалгалтын материал, дүгнэлттэй танилцах, харицуулалт хийх;

8. Шалгалтад хамрагдахгүй үлдэж байгаа асуудал байгаа эсэхийг нягтлах,

9. Шалгалтын материалыг ТУЗ, түүний дэргэдэх хороодод танилцуулсан байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлттэй танилцах;

10. ТУЗ болон түүний дэргэдэх хорооны шалгалтын материалыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрлэсэн байдал, авсан арга хэмжээ, түүний дагуу хийгдсэн ажлуудын биелэлттэй танилцах;

11. Банкны МУТС-тэй тэмцэх тогтолцооны бусад үзүүлэлтүүдийг шалгаж байгаа хянан шалгагч нартай дотоод хяналт шалгалтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт болон банкны МУТС-тэй тогтолцооны сул тал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн ерөнхий байдлын талаар мэдээлэл солилцох;

12. Өмнөх шалгалт, болон зайнаас тавих хяналтын хүрээнд банкны дотоод хяналтын тогтолцоотой холбоотой өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянах.

13. Бусад чиглэлээр шалгалт хийж байгаа хянан шалгагч нартай зөвлөх, дотоод хяналтын нэгжийн шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг нягтлах, асууж тодруулах.

ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:

*Харилцагчийг таньж мэдэх, харилцагч, данс болон гүйлгээний талаарх баримт, материалын хадгалалт /журмын 3.1.5-д хамаарна/;*

#### **Зорилт:**

МУТС-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхийн тулд банк хэнтэй санхүүгийн харилцаанд орж байгаагаа сайн мэдэж байх нь туйлын ач холбогдолтой юм. Харилцагчийн эрхэлдэг ажил, бизнесийн төрөл, түүний цар хүрээ, үйл ажиллагаа явуулдаг газар, хаана бүртгэлтэй болох, аль улсын харьяат болох, хэнийг төлөөлөн бизнесийн харилцаанд орж байгааг нь мэдэх нь банкны хувьд МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлээс хамгаалах зорилгоор зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа юм. МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд ХТМ талаар банк, санхүүгийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээг зааж өгсөн. Банк өндөр эрсдэлтэй харилцагчийн тухайд ХТМ үйл ажиллагааг илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан хэлбэрээр явуулах шаардлагатай.

Банк ХТМ, тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд харилцагчаас гаргуулан авсан баримт, мэдээлэл болон харилцагчийн данс, гүйлгээтэй холбоотой бүх мэдээллийг тухайн данс хаагдсанаас эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш/дансгүй харилцагчийн хувьд/ 5-аас доошгүй жил хадгалах үүрэгтэй.

Хянан шалгагч нь банкны ХТМ үйл ажиллагаа нь МУТС-тэй тэмцэх тухай хууль

болон МБ-ны Ерөнхийлөгчийн баталсан ХТМ-тэй холбоотой журмуудад нийцэж байгаа эсэхийг тогтоох, банкны ХТМ дотоод бодлого журам, түүний хэрэгжилтийг үнэлэх, ФАТФ-ын 40 зөвлөмжийн ХТМ-тэй холбоотой зөвлөмжүүдтэй уялдуулан банкны ХТМ үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорино.

### **Шалгуур үзүүлэлт:**

1. Банк ХТМ бодлого, журамтай эсэх;
2. Банкны ХТМ бодлого, журам нь МУТС-тэй тэмцэх тухай хууль тогтоомжтой нийцтэй эсэх;
3. ХТМ бодлого, журам нь банкны үйл ажиллагааны цар хүрээ, бүтээгдэхүүний, үйлчилгээний онцлогт тохирч байгаа эсэх;
4. Эцсийн өмчлөгч, улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох үйл явц нь хэрэгжих боломжтой байдлаар бодлого, журамд тусгагдсан эсэх;
5. Дансгүй харилцагчийн хувьд ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдлуудыг тодорхой тусгасан эсэх, орхигдсон, хэрэгжүүлэх шаардлагатай зүйлсийг байгаа эсэх;
6. Корреспондент банкны харилцаа тогтоохын өмнө харилцагч банк, санхүүгийн байгууллагыг таньж мэдэх үйл ажиллагаа хийгддэг эсэх;
7. Корреспондент банкны харилцаа тогтоохын өмнө банкны удирдлагад танилцуулан, зөвшөөрөл авдаг эсэх;
8. Харилцагчийн эрсдэлийн үнэлгээтэй ХТМ үйл ажиллагааг уялдуулан өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчлан таних үйл ажиллагаа хийгддэг эсэх;
9. Хялбаршуулсан байдлаар ХТМ үйл ажиллагааг хийх харилцагчийг зөв тодорхойлж байгаа эсэх;
10. Харилцагч банкинд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан эсхүл тодорхой хугацаанд гаргаж өгөхгүй байгаа тохиолдолд банк үйлчилгээ үзүүлэхээс татгалздаг эсэх;
11. Харилцагчийг мэдээллийг шинэчлэх үйл ажиллагаа хэрхэн хийгддэг, харилцагчийн талаарх мэдээлэлд үндэслэн гаргасан дүгнэлт, эрсдэлийн түвшин, шаардлагатай тохиолдолд хөрөнгийн эх үүсвэрийн талаарх олж авсан мэдээлэлтэй тухайн харилцагчийн хийж байгаа гүйлгээ нь бизнесийн харилцааны туршид хэвээр байгаа гэдгийг нягтлан таньж мэдэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулж, баримтжуулдаг эсэх ;
12. Данс нээх гүйлгээ хийхийн өмнө НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий



төрийн байгууллагаас террорист гэж үзсэн этгээдийн нэрсийн жагсаалттай тулган шалгах ажиллагаа хийгддэг эсэх, энэ ажиллагаа бодит цагийн горимоор, автомажуулалт ашиглан хийгддэг эсэх;

13. НҮБ-ын хоригт орсон эсхүл ФАТФ-ын хар жагсаалтад орсон орны харилцагч байгаа эсэхийг нягтлан үзэх;

14. Цахим шилжүүлэг хийх, дамжуулах, хүлээн авахад тохиолдолд гүйлгээнд оролцогч талуудын талаарх мэдээллийн бүрэн эсэхэд хяналт тавьдаг эсэх;

15. Харилцагчийн данс, гүйлгээтэй холбоотой мэдээллийн хадгалалт хууль тогтоомжид заасан хугацаа, нөхцөлийг хангаж байгаа эсэх;

16. Банкны дотоод хяналт шалгалтын нэгжээс дээрх чиглэлээр хийгддэг хяналт шалгалтын аргачлал, давтамж, хамрах хүрээ нь оновчтой эсэх;

### **Шалгах арга хэлбэр:**

1. Банкны ХТМ үйл ажиллагааг зохицуулсан бодлого журамтай танилцах;
2. Банкны хэрэгжилт хариуцсан ажилтан, данс нээх, гүйлгээ хийх чиг үүрэг бүхий газар нэгжийн удирдлага, ажилтнуудтай ярилцлага хийх;

3. ХТМ үйл ажиллагааны хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, Түүврийг хийхэд банкны нийт харилцагчийн тоог харгалзахын зэрэгцээ, дансаа идэвхтэй ашигладаг, өндөр дүнтэй гүйлгээ хийдэг, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, оршин суугч болон оршин суугч бусын данс, улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн бус байгууллагууд, ББСБ зэргийг хамруулана. Түүнчлэн ХТМ нарийвчилсан үйл ажиллагаа хийгдэх шаардлагатай харилцагчдын дансыг түүвэрт түлхүү оруулахад анхаарна. Түүвэрлэсэн дансаа дараах шалгах хүснэгтийг ашиглан шалгана:

<b>ДАНС ТҮҮВЭРЛЭН ШАЛГАХ ХУУДАС</b>	
<b>МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН НЭР:</b>	<b>ОГНОО:</b>
<b>БАЙРШИЛ:</b>	<b>ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:</b>
<b>Харилцагчийн нэр:</b>  (Харилцагч нь хуулийн этгээд бол түүний гүйцэтгэх удирдлагын нэр, хувьцаа эзэмшигчдийн нэр, эцсийн өмчлөгчийн нэр болон төлөөлөн гүйлгээ хийх эрх бүхий этгээдийн нэрийг оруулан бүгдийг жагсаах)	

**Албан ёсны хаяг:**

(Бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулдаг хаяг)

**Данс нээсэн талаарх мэдээлэл:**

Нээгдсэн огноо:

Данс нээсэн салбар:

Хамгийн сүүлд мэдээллийн шинэчлэл хийгдсэн огноо:

**Бичиг баримтын баримтжуулалт:**

(Харилцагчаас гаргуулан авсан хувийн хэрэгт байгаа бүх баримт материалыг жагсаах)

**Харилцагч өөр байгууллагаас шилжиж ирсэн эсэх:**

Шилжиж ирсэн оноо:

Шилжүүлсэн байгууллагын нэр:

ХТМ шаардлагатай баримт мэдээлэл байгаа эсэх:

**Бизнесийн зорилго ба данс нээх болсон шалтгаан:**

(Бизнесийн чиглэл, зорилго болон данс нээх болсон шалтгааны талаарх тодорхой мэдээлэл авсан эсэх; үүнтэй холбоотой мэдээллийг оруулах)

**Харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагаа:**

(Энэ ажиллагааг хэн хийж гүйцэтгэсэн бэ? Хийсэн огноо, шалтгааны талаарх мэдээллийг оруулах)

**Эрсдэлийн үнэлгээ болон тусгайлан хяналт:**

(огноо, хяналтын давтамж, дансанд хяналт тавьсан эсэхийг нотлох нотолгоо)

Эрсдэлийн үнэлгээ:

**Харилцагчийг таньж мэдэх бодлого журамд нийцэхгүй зүйлс:**

(байгаа бол энд жагсааж бичих)

**Дансаар дамжсан мөнгөний гарал үүсэл:**

(Үүнд мөнгөн дүн, валютын төрөл, хүлээн авсан огноо зэрэг мэдээлэл)

Анхны мөнгөн дүн:

Дансаар хийгдсэн орлогын гүйлгээний дүн:

(эдгээр нь харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэх)

Давтамж:

**Дансны гарсан гүйлгээ:**

(Үүнд мөнгөн дүн, валютын төрөл, огноо зэрэг мэдээлэл)

Хүлээн авагч:

(Хүлээн авагч нь 3 дагч этгээд бол төлбөрийн шалтгааны талаар банк ойлголт авч мэдээлэл цуглуулсан эсэх)

Хугацаа:

**Хамгийн сүүлд хийгдсэн гүйлгээний мэдээлэл**

Огноо:

Мөнгөн дүн:

Гүйлгээний утга:

**Бэлэн мөнгөн гүйлгээг мэдээлэх:**

(энэ дансаар хийгдсэн 20 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээг СМА-нд мэдээлсэн эсэх)

Огноо:

Мөнгөн дүн:

Валютын төрөл:

**Гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх:**

(энэ дансаар хийгдсэн 20 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй ГТТГ-г СМА-нд мэдээлсэн эсэх)

Огноо:

Мөнгөн дүн:

Валютын төрөл:

**Сэжигтэй гүйлгээг мэдээлэх:**

СМА-нд мэдээлсэн огноо:

Сэжигтэй гэж илрүүлээд СМА-нд мэдээлэх шаардлагагүй гэж үзсэн бол шалтгааныг баримтжуулсан эсэх;

**Бусад тайлбар:**

**Данстай холбоотой баримт материал, мэдээллийг гаргаж өгч, шалгуулсан ажилтны нэр:**

**Гарын үсэг:**

**Огноо:**

--

4. Дансгүй харилцагчийн тухайд ХТМ үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгааг түүврийн аргаар шалгана. Түүврийг хийгдээ шалгалтын хамрах хугацаанд сар бүрийн хамгийн өндөр дүнтэй гүйлгээнүүд, олон удаа давтагдсан гүйлгээ зэргийг хамруулна. Шалгалтын хамрах хугацаанд хийгдсэн дансгүй харилцагчийн банк хоорондын гүйлгээ, гуйвуулгыг дараах шалгах хүснэгтийг ашиглан шалгана:

<b>ДАНСГҮЙ ХАРИЛЦАГЧИЙН БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ БОЛОН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ГҮЙЛГЭЭГ ТҮҮВЭРЛЭН ШАЛГАХ ХУУДАС</b>	
<b>МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН НЭР:</b>	<b>ОГНОО:</b>
<b>БАЙРШИЛ:</b>	<b>ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:</b>
<b>Харилцагчийн нэр:</b>  (Харилцагч нь хуулийн этгээд бол түүний гүйцэтгэх удирдлагын нэр, хувьцаа эзэмшигчдийн нэр, эцсийн өмчлөгчийн нэр болон төлөөлөн гүйлгээг хийсэн этгээдийн нэрийг оруулан бүгдийг жагсаах)	
<b>Гүйлгээний тухай мэдээлэл:</b>  Гүйлгээг хийсэн харилцагчийн нэр, хаяг:  Гүйлгээний дүн:  Валютын төрөл:  Гүйлгээг хийсэн огноо:  Хүлээн авагчийн банкны нэр:  Хүлээн авагчийн нэр, дансны дугаар эсхүл регистр/хаяг:  Гүйлгээний утга:	
<b>Гүйлгээтэй холбоотой ХТМ үйл ажиллагаа:</b>	

( Иргэний үнэмлэх, паспорт гэх харилцагчаас гаргуулан авсан бүх баримт материалыг жагсаах )

**Гүйлгээний зорилго:**

( Гүйлгээний утга, зорилготой холбоотой гэрээ, хэлцэл гэх мэт бүх нэмэлт материалыг жагсаах )

**ХТМ үйл ажиллагааг нарийвчлан хийсэн эсэх:**

Хэн хийсэн:

Хийх болсон шалтгаан:

Хийсэн огноо:

**Хамгийн сүүлд хийгдсэн гүйлгээний мэдээлэл:**

Огноо:

Мөнгөн дүн:

Хүлээн авагчийн нэр:

Хүлээн авагчийн банк:

Хүлээн авагчийн дансны дугаар эсхүл нэр, регистр/хаяг:

Гүйлгээний утга:

**Бэлэн мөнгөн гүйлгээг мэдээлэх:**

(энэ харилцагчийн хийсэн 20 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээг СМА-нд мэдээлсэн эсэх)

Огноо:

Мөнгөн дүн:

Валютын төрөл:

**Гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх:**

(энэ харилцагчийн хийсэн 20 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй ГТТГ-г СМА-нд мэдээлсэн эсэх)

Огноо:

Мөнгөн дүн:

Валютын төрөл:
<b>Сэжигтэй гүйлгээг мэдээлэх:</b> СМА-нд мэдээлсэн огноо: Сэжигтэй гэж илрүүлээд СМА-нд мэдээлэх шаардлагагүй гэж үзсэн бол шалтгааныг баримтжуулсан эсэх;
<b>Бусад тайлбар:</b>
<b>Гүйлгээтэй холбоотой баримт материал, мэдээллийг гаргаж өгч, шалгуулсан ажилтны нэр:</b> <b>Гарын үсэг:</b> <b>Огноо:</b>

5. Дээрх түүврүүдийг ашиглан харилцагчийн мэдээллийг шинэчлэсэн байдалд мөн дүгнэлт хийнэ;

6. Хялбаршуулсан байдлаар ХТМ үйл ажиллагаа хийгдсэн бүх харилцагчийн жагсаалтыг гаргуулан авч нягтлан үзнэ;

7. Банк МУТС-тэй тэмцэх тухай хуульд заасан бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийн хувьд ХТМ хэрхэн хэрэгжүүлдэгийг түүвэрлэн шалгах;

8. Харилцагчаас гаргуулан авах баримт, мэдээлэл дутуу бол түүний шалтгааныг тогтоох, банк шаардлагатай баримт, мэдээллийг өгөхөөс татгалзсан эсхүл гаргаж өгөхгүй яваад байгаа харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзаагүй шалгааныг тогтоож холбогдох арга хэмжээ авах;

9. Нэргүй, дугаарласан эсхүл илт хуурамч нэрээр нээсэн данс байгаа эсэхийг шалгах;

10. Корреспондент банкны харилцаа тогтоохийн өмнө банк нь тухайн банк, санхүүгийн байгууллага нь бодитоор оршдог эсэхийг тогтоосон баримт мэдээлэл байгаа эсэх, тухайн банкны МУТС-тэй тэмцэх тогтолцооны талаар асуулга илгээж хариу авсан эсэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухайн банкны талаар гарсан мэдээллийг судлаж үзсэн эсэх, тухайн банкны корреспондент банкны харилцаа тогтоохыг банкны удирдлага зөвшөөрсөн шийдвэр гарсан эсэх, эдгээрийг нотлох баримтыг гаргуулан авч танилцана;

11. Шалгалтын хамрах хугацаанд цуцалсан корреспондент банкны харилцаа байгаа эсэх, байгаа бол шалтгааны тодруулах;

12. Корреспондент банкуудаас ирүүлсэн гүйлгээтэй холбоотой тодруулга, асуулгын нэгдсэн жагсаалтыг гаргуулан авч танилцах, түүвэрлэн шалгах;

13. Банкны хаагдсан данс болон 5 жил хүртэл хугацааны өмнө хийгдсэн гүйлгээнээс түүвэрлэн авч тухайн данс гүйлгээтэй холбоотой банкинд хадгалагдаж байгаа баримт, мэдээллийн бүрэн байдлыг шалгана;

14. ХТМ үйл ажиллагаа болон бичиг баримтын хадгалалттай холбоотой банкны дотоод хяналт шалгалтын нэгжээс хийсэн сүүлийн 2 удаагийн шалгалтын материалтай танилцаж, шалгалтын арга, хамрах хүрээ, давтамж нь оновчтой эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг засах талаар хийгдсэн ажлын тайлантай танилцаж өөрийн шалгалтын түүврийг хийхэд хамруулах, анхаарах зүйлсийг тогтооно.

15. Өмнөх шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах;

16. Бусад үзүүлэлтүүдийг шалгаж байгаа хянан шалгагч нартай мэдээлэл солилцох, уялдаа, холбоог хангаж ажиллах.

ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:

***МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр түүний хэрэгжилт/журмын 3.1.6-д хамаарна. /***

### **Зорилт.**

Банкны удирдлага болон нийт ажилтнууд МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны олон улсын стандарт, дотоодын хууль эрх зүйн орчин болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, журмын талаар мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай.

Түүнчлэн өөрийн банкны МУТС-тэй тэмцэх дотоод бодлого, журам, аргачлалыг нийт ажилтнууддаа тайлбарлан таниулах, ажлын байрны онцлогийг нь харгалзан сургалтын тусгай хөтөлбөрт хамруулах, МУТС гэмт хэрэг үйлдэгдэж байгаа арга хэлбэр, чиг хандлагын талаар мэдээлэл өгч байх нь МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой.

Тодорхой сургалтын хөтөлбөрийн дагуу танхимын сургалт явуулахыг зэрэгцээ банкны дотоод цахим орчинд МУТС-тэй тэмцэх чиглэлээр гарсан шийдвэр, зохицуулалт, гарын авлага болон МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийгдэж буй ажлуудын талаар нийт ажилтнуудыг мэдээллээр хангаж ажиллах нь МУТС-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөөтэй.



Энэ хэсэгт хянан шалгагч нь банкны МУТС-тэй тэмцэх, түүнээс урдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийн агуулга, ажилтнуудын сургалтад хамрагдсан байдал болон сургалтын хөтөлбөр тэдний ажлын байрны онцлогт хэр нийцтэй байгаа талаар дүгнэлт хийхийн зэрэгцээ банкны удирдлагын зүгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж бололцоогоор хэрхэн хангаж байгаад үнэлэлт дүгнэлт өгөхийг зорино.

### **Шалгуур үзүүлэлт:**

1. Банк МУТС-тэй тэмцэх чиглэлээр батлагдсан сургалтын хөтөлбөртэй эсэх;
2. Банкны удирдлага болон нийт ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр, шинэ ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр, ажлын байрны онцлогт зориулсан сургалтын хөтөлбөр зэрэг тухайлсан сургалтын хөтөлбөртэй эсэх;
3. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны олон улсын стандарт болон дотоодын хууль эрх зүйн орчинд нийцтэй эсэх;
4. Сургалтын давтамж, банкны салбар нэгжийн ажилтнуудын хамрагдсан байдал;
5. Данс нээх, гүйлгээ хийх, гэх мэт харилцагчтай ойр ажиллаж байгаа ажилтнуудын ажлын байрны шаардлагад МУТС-тэй тэмцэх чиглэлээр тодорхой цагийн сургалтын хөтөлбөрт хамрагдсан байх гэсэн шалгуур байдаг эсэх; ХТМ үйл ажиллагаа болон сэжигтэй гүйлгээний талаар илүү нарийвчлсан сургалтын хөтөлбөрт хамрагддаг эсэх;
6. СМА, Монголбанк болон бусад дотоод, гадаадын байгууллагуудаас зохион байгуулсан МУТС-тэй тэмцэх чиглэлийн сургалтад банкны хэрэгжилт хариуцсан ажилтан болон бусад ажилтнуудын хамрагдсан байдал;
7. Банкны удирдлагын зүгээс сургалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв, дотоод, гадаад сургалтад хамрагдах нөхцөл бололцоог бүрдүүлсэн эсэх;
8. Сургалтын чанар, үр өгөөж болон хөтөлбөрийн агуулга, хэлбэр, ажилтнуудын хамрагдсан байдалд банкны дотоод хяналт шалгалтын нэгжээс хэрхэн хяналт тавьдаг;
9. Зайнаас тавих хяналтын хүрээнд банкнаас сургалттай холбоотой ирүүлсэн мэдээллийн бодит байдал болон өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутгадлыг засч залруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

### **Шалгах арга хэлбэр:**

1. Банкны удирдлагын баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө болон сургалтын төсвийг гаргуулан авч танилцах;
2. Нийт ажилтнуудад зориулсан, шинэ ажилтанд зориулсан эсхүл ажлын байрны

онцлогт нь тохируулсан сургалтын хөтөлбөр байгаа эсэхийг тодруулж, тэдгээр сургалтад ашигладаг материалуудыг гаргуулан авч танилцах;

3. Сургалтын материалууд нь агуулгын хувьд дараах асуудлуудыг хамарч чадсан эсэхийг нягтлах. Үүнд:

- МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны олон улсын стандарт болох ФАТФ-ын 40 Зөвлөмжийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой Зөвлөмж 9-23 болон МУТС-тэй тэмцэх тухай хууль, түүнтэй холбогдуулан Засгийн газрын тогтоол, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмуудыг хамруулсан байдал;
- Банкны дотоод бодлого, журмыг хэрхэн хэрэгжүүлэх арга хэлбэрийг тусгасан байдал;
- МУТС эрсдэлийн тухай ойлголт, банкны МУТС эрсдэлийн үнэлгээний аргачлал болон ажилтнуудын анхаарах зүйлсийн талаар тусгасан байдал;
- НҮБ болон Тагнуулын Ерөнхий газраас террорист этгээдийн жагсаалтыг хэрхэн ашиглах;
- Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, НҮБ-ын хоригийн тогтоол ФАТФ-ын хар жасгаалыг хэрхэн ашиглах;
- Өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагаа хэрхэн хэрэгжүүлэх;
- ХТМ үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх арга хэлбэрийг тусгасан байдал;
- Дансгүй харилцагчийн хувьд ХТМ үйл ажиллагааг явуулах шаардлагатай тохиолдолууд;
- Эцсийн өмчлөгчийн тухай ойлголт болон түүнийг тогтооход баримтлах журам, заавар;
- Банк хоорондын гүйлгээ болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг хийхэд ХТМ шаардлагууд;
- Корреспондент банкны харилцааг тогтооход МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Сэжигтэй гүйлгээний тухай ерөнхий ойлголт, жишээ, гүйлгээг сэжиглэсэн тохиолдолд хэрэгжүүлэх алхамууд;
- Данс, гүйлгээ болон ХТМ үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан баримт, мэдээллийн хадгалалт;

- Банкны үйл ажиллагаанд хориглосон зүйлс болон хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлага;

4. Сургалтад ажилтнуудын хамрагдсан байдлын бүртгэл, судалгаатай танилцах;

5. Банкны ажилтнуудаас сонгон ярилцлага хийх;

6. Урьдчилан бэлтгэсэн товч асуултуудад хариулт авах;

7. Хэрэгжилт хариуцсан ажилтан, банкны хүний нөөцийн хариуцсан нэгжийн удирдлага болон холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх;

8. Банкны дотоод хяналтын нэгжээс МУТС-тэй тэмцэх чиглэлийн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг шалгаж дүгнэсэн байдалтай танилцах;

9. Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт болон зайнаас тавих хяналтын хүрээнд банкнаас ирүүлсэн тайлан, мэдээтэй танилцах;

ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ:

*Данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих болон, мэдээлэх үүрэгтэй холбоотой банкны үйл ажиллагаа /журмын 3.1.7-д хамаарна. /*

#### **Зорилт:**

Түүнчлэн банк огцом өөрчлөгдсөн их дүнтэй гүйлгээ, эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй гүйлгээ, улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн гүйлгээ болон МУТС-тэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй улсаар дамжуулан хийгдсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавих үүрэгтэй. Тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд харилцагчаас гүйлгээний утга, зорилго, оролцогч талуудын талаар нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулан авах, шаардлагатай баримт материалыг нэмж бүрдүүлэх, дүн шинжилгээ хийж сэжигтэй гэж үзсэн тохиолдолд СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

Банк НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор болон эрх бүхий төрийн байгууллагаас террорист гэж зарласан этгээдийн нэрсийн жагсаалттай харилцагч болон гүйлгээнд оролцогч талуудын мэдээллийг данс нээх, гүйлгээ хийх бүрдээ тулган шалгаж, нэр тохирсон тохиолдолд данс, гүйлгээг нэн даруй царцааж СМА болон ТЕГ-т мэдээлэх үүрэгтэй.

Түүнчлэн НҮБ-ийн хориг болон ФАТФ-ын хар жагсаалтад орсон улс орны эсрэг хоригт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Энэ хэсэгт хянан шалгагч нь банк тусгайлан хяналт тавих үүргээ хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх хэрхэн хэрэгжүүлэ байгаа болон мэдээлэх үүрэгтэй гүйлгээг батлагдсан маягт, зааврын дагуу хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж байгаа эсэхийг

тогтоох, гүйлгээг мэдээлэх үйл ажиллагаанд хүний хүчин зүйлсээс хамаарах санаатай, санамсаргүй үйлдэл хийгдэх боломж байгаа эсэхийг тогтоох, сэжигтэй гүйлгээг таньж илрүүлэх болон мэдээлэх тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорино.

МУТС-тэй тэмцэх тухай хуулийн дагуу банк нь Монголбанкны СМА-нд 3 төрлийн гүйлгээний тайланг батлагдсан маягт, зааврын дагуу хуульд заасан хугацаанд мэдээлэх үүрэгтэй:

1. 20 сая төгрөг/түүнтэй тэнцэх гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний тайлан/БМГТ/;
2. 20 сая төгрөг/түүнтэй тэнцэх гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан/ГТТГТ/;
3. Сэжигтэй гүйлгээний тайлан/СГТ/.

БМГТ болон ГТТГТ-г гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Сэжигтэй гүйлгээний тухайд банк уг гүйлгээг сэжигтэй гэж үзсэн эсхүл мэдсэнээс хойш 24 цагийн дотор СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Сэжигтэй гүйлгээний тухайд 20 сая төгрөг гэсэн босго байхгүй, түүнээс бага дүнтэй гүйлгээ ч байж болохын зэрэгцээ нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий тодорхойлолт, тогтсон хэв шинж гэж байхгүй боловч харилцагчийн тогтмол хийдэг гүйлгээ, эрхэлж буй ажил, бизнесийн төрөл, цар хүрээ, гүйлгээний дүн, утга, харилцагчийн иргэншил, бүртгэлтэй болон үйл ажиллагаагаа явуулдаг улс орон, харилцагчийн зан байдал зэрэг олон үзүүлэлтийг нэгтгэн авч үзэхэд өөр хоорондоо логикийн зөрчилтэй байх тохиолдолд хэрэгжилт хариуцсан ажилтан энэ байдлыг тодруулах боломжит бүх арга хэмжээг аваад сэжигтэй гэж үзсэн тохиолдолд 24 цагийн дотор СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Үүний тулд банк ХТМ үйл ажиллагааг нухацтай хэрэгжүүлэхийн зэрэгцээ данс, гүйлгээнд хяналт тавих тогтолцоо бүрдсэн байх шаардлагатай.

### **Шалгуур үзүүлэлт:**

1. Тусгайлан хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн хийгддэгтэй танилцах, хяналт тавих данс, гүйлгээг хэрхэн тогтоож байгаа аргатай танилцах, хууль тогтоомж, эрсдэлийн үнэлгээтэй нийцэж байгаа эсэхийг шалгах, сул тал байгаа эсэхийг дүгнэх;
2. Огцом өөрчлөгдсөн их дүнтэй, эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй болон улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн гүйлгээнд хяналт тавьж байгаа эсэх, ямар арга хэлбэр ашигладаг;
3. ФАТФ-ын хар жагсаалтад орсон улс орны харилцагч болон тэдгээр улс орноор дамжин хийгдсэн гүйлгээнд хориг арга хэмжээ авч байгаа эсэх, хяналт тавих тогтолцоо байгаа эсэх, ямар арга хэлбэр ашигладаг.

4. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлдэг;

5. ФАТФ-ын саарал жагсаалтад орсон улс орны харилцагч болон тэдгээр улс орноор дамжин хийгдсэн гүйлгээнд ХТМ нарийвчилсан арга хэмжээ болон гүйлгээний зорилго, утга, хөрөнгийн гарал үүслийг тогтоох нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлдэг эсэх, харилцагч цаашид үргэлжлүүлэх эсэхийг хэрхэн шийддэг;

6. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан террорист этгээдийн нэрсийн жагсаалтыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эсэх;

7. Жагсаалтуудыг хэзээ, хэрхэн шинэчилдэг;

8. Данс, гүйлгээг царцаах, болон эрх бүхий төрийн байгууллагад мэдээлэх зохицуулалт байгаа эсэх, энэ нь нэн даруй хугацаа алдалгүй хэрэгжүүлэх боломжтой эсэх;

9. Тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан материал, хийсэн дүн шинжилгээ, дүгнэлттэй танилцах; Шаардлагатай гэж үзсэн гүйлгээг сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэхийг үүрэг болгох;

10. Данс гүйлгээг царцаах талаар баримтлах бодлого, журам зохицуулалт байгаа эсэх, НҮБ болон эрх бүхий байгууллагаас гаргасан

11. Банк бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх үйл ажиллагааг зохицуулсан бодлого, журамтай эсэх, энэ зохицуулалт нь холбогдох хууль журамд нийцсэн эсэх;

12. Мэдээлэх үүрэгтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг хэрхэн ангилж ялгадаг, банкны бүх салбар, тооцооны төвөөр хийгдэж байгаа, VIP харилцагч, дансгүй харилцагч, цүнхээр мөнгө тушаадаг этгээд зэрэг бүх харилцагчийн гүйлгээг бүрэн хамарч чадаж байгаа эсэх;

13. Системээс ялгаж авсан 20 саяаас дээш дүнтэй бэлэн болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг хууль заасан хугацаанд батлагдсан маягт, хэлбэрийн дагуу СМА-нд мэдээлж байгаа эсэх;

14. Банк сэжигтэй гүйлгээг таньж илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой журам, заавартай эсэх, энэ нь үр дүнтэй хэрэгжих боломжтой эсэх;

15. Банк сэжигтэй гүйлгээг илрүүлэх зорилгоор гүйлгээнд хяналт тавих тогтолцоотой эсэх, програм хангамж ашигладаг бол програмд оруулсан дохио өгөх, анхааруулах нөхцөлүүд нь оновчтой эсэх;

16. Сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд чиглэсэн зохицуулалт болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь харилцагчийн онцлог, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид

хүргэх арга хэлбэр, салбар нэгжийн байршлаас хамаарах эрсдэлийн үнэлгээ болон улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд олон улсын байгууллагаас өгсөн үнэлгээтэй уялдаатай эсэх;

17. Хэрэгжилт хариуцсан ажилтан нь сэжигтэй гүйлгээг илрүүлэх тогтолцооны таньж илрүүлсэн гүйлгээтэй холбоотой дүн шинжилгээ хийх, нэмэлт мэдээлэл цуглуулах, тусгайлан хяналт тавих зэрэг арга хэмжээ авдаг эсэх, эдгээр арга хэмжээний хүрээнд хийсэн ажлаа баримтжуулан хадгалдаг эсэх;

18. Хэрэгжилт хариуцсан ажилтан нэмэлт дүн шинжилгээ хийсний эцэст СГТ-аар мэдээлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд ингэж дүгнэсэн шалгаан, холбогдох мэдээллийн хамт баримтжуулж байгаа эсэх;

19. СМА-нд илгээсэн СГТ-ын бүртгэл хөтөлдөг эсэх;

20. Гүйлгээг сэжигтэй гэж үзэн СГТ-аар СМА-нд мэдээлэх шийдвэрийг хэн гаргадаг, мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хэрхэн хангадаг, харилцагчид хийсэн гүйлгээг нь СГТ-аар мэдээлсэн эсхүл мэдээлэх гэж байгаа талаар ямар нэг байдлаар мэдэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн эсэх;

### **Шалгах арга хэлбэр:**

1. Банкны бэлэн мөнгөний, гадаад төлбөр тооцооны болон сэжигтэй гүйлгээг мэдээлэх үйл ажиллагааг зохицуулсан бодлого, журамтай танилцах;

2. БМГТ ба ГТТГТ бэлтгэх, мэдээлэх үйл ажиллагаа хэрхэн хийгддэг талаар хэрэгжилт хариуцсан ажилтан болон банкны бусад холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх;

3. Банкны ашиглаж буй програм хангамжтай танилцах, ямар дүрмээр ажилладаг болохыг нь тайлбарлуулах, цүнхээр авч байгаа мөнгө болон ажлын нэг өдрийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн дүн 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют)-өөс бага боловч нийт дүн нь 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээг таних дүрэм байгаа эсэхийг тодруулах, туршиж үзэх, дүрмийг хэрхэн өөрчлөж болохыг тайлбарлуулах, дүрмийг өөрчлүүлэн туршиж үзэх;

4. Банк НҮБ болон эрх бүхий төрийн байгууллагаас гаргасан террорист этгээдийн жагсаалтыг ашиглаж байгаа эсэх, жагсаалтыг хэрхэн шинэчлэдэг болон тулган шалгах ажиллагаа бүх төрлийн гүйлгээ, данс нээх үйл ажиллагаатай хослон хэрэгжиж байгаа эсэхийг шалгах

5. НҮБ хориг болон ФАТФ-ын хар жагсаалтыг хэрхэн ашиглаж байгаа програм хангамжийн түвшинд зохицуулалт хийгдсэн эсэхийг шалгах;

6. Данс, гүйлгээг царцаах бүх салбар нэгжээс уг гүйлгээг хийх, данснаас зарлагын гүйлгээ хийхийг зогсоох програм хангамжийн түвшинд боломж байгаа эсэхийг шалгах;

7. Шалгалтын хамрах хугацааны БМГТ болон ГТТГТ-г програм хангамжийг ашиглан дахин хийж үзэж, СМА-наас авсан БМГТ болон ГТТГТ-ын тоотой тулгаж үзэх, зөрүүтэй байгаа тохиолдолд СМА-нд мэдээлсэн БМГТ болон ГТТГТ-ын бүртгэл эсхүл архивласан файл болон СМА-наас банкны ирүүлсэн тайлангийн тооны задаргааг гаргуулан авах замаар шалтгааныг олох;

8. Банкны сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэхэд чиглэсэн журам, заавартай танилцах, түүнийг хэрхэн хэрэгжүүлдэг талаар хэрэгжилт хариуцсан ажилтантай ярилцлага хийх;

9. Банкны сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд чиглэсэн хяналтын тогтолцоо, програм хангамжийн ажиллагаатай танилцах, хэр оновчтой шалгуурууд ашиглан гүйлгээг хянаж байгааг дүгнэх;

10. Хэрэгжилт хариуцсан ажилтны сэжигтэй гүйлгээг илрүүлэх зорилгоор хийсэн дүн шинжилгээ, тусгайлан хяналт тавьсан данс, гүйлгээтэй холбоотой баримт материал, бүртгэл, дүгнэлттэй танилцах;

11. МУТС эрсдэлийн үнэлгээг сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд хэрхэн ашиглаж байгаатай танилцах;

12. Шалгалтын хамрах хугацаанд СМА-нд илгээсэн СГТ-ын тоо, зайнаас хяналтын хүрээнд банкинд өгсөн эрсдэлийн үнэлгээ болон банкны өөрийн хийсэн эрсдэлийн үнэлгээг анхааралдаа авч сэжигтэй гүйлгээг таньж илрүүлэхэд чиглэсэн банкны үйл ажиллагааны оновчтой байдал, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

13. Банкны дотоод хяналтын нэгжээс энэ чиглэлээр хийсэн хяналт шалгалтын дүгнэлттэй танилцах, энэ дүгнэлтийн талаар санал сэтгэгдэлээ банкны дотоод хяналтын тогтолцоог шалгаж байгаа хянан шалгагчтай хуваалцах;

14. Өмнөх шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцах;

